

## **ХЯТАДААС МОНГОЛД ОРУУЛЖ БУЙ ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ҮР ӨГӨӨЖ**

*Түмэнцэцэг\**

Товч агуулга: Сүүлийн жилүүдэд Хятадаас Монголд оруулж буй шууд хөрөнгө оруулалт илт хурдан нэмэгдэж, хөрөнгө оруулалтын хүрээ тэлж, үүний дотроос Монголын уул уурхайн салбарт оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ тасралтгүй өсч байна. Хятадаас Монголд оруулж буй шууд хөрөнгө оруулалт нь хөрөнгө оруулагч орны ажилгүйдлийн тоо хэмжээ өсөн нэмэгдэхэд идэвхитэй нөлөөлж, улмаар хөрөнгө татаж буй тухайн газрын цалингийн хэмжээ нэмэгдэхэд үүрэг гүйцэтгэж байгаагаас гадна, Монгол Улсын гадаад худалдааны тэнцвэр ба үйлдвэрлэлийн технологийн өсөлтийн хэмжээ тогтворжиход нааштай үр өгөөжөө өгч байна.

Түлхүүр үг: Монгол, Хятадын харилцаа, шууд хөрөнгө оруулалт, өнөөгийн байдал, үр өгөөж.

Монгол Улс бол Хятадын умардын чухал хөрш, 1994 онд хоёр тал “Хятад, Монголын найрамдал, хамтын ажиллагааны гэрээ”-нд гарын үсэг зурж, хоёр орны харилцааг эрүүлжүүлэх, тогтвортой хөгжлийн улс төр, хууль эрх зүйн үндсийг тавилаа. Сүүлийн жилүүдэд, Хятадын эдийн засаг, нийгмийн хурдацтай хөгжил ба хөрш орнуудын гео-эдийн засгийн хамтын ажиллагааны хурдацтай алхамыг дагалдаад хоёр орны харилцаа түргэн хөгжиж, дээд хэмжээний харилцан айлчлал байнга явагдаж, үр дүн нь ахиж, хоёр орны улс төр, эдийн засаг, соёлын зэрэг бүхий л салбарын хамтын ажиллагаа нэлээд ахиж, түүхийн хамгийн сайн хөгжлийн үед орлоо. Одоо хоёр орны харилцан ашигтай хамтын ажиллагаа тасралтгүй өргөжиж, Монгол Улс нэгэнт Хятадын гадаадад хөрөнгө оруулж буй нэн чухал газар болж, улмаар Хятад улс, Монгол Улсын хамгийн том худалдааны түнш, хамгийн том хөрөнгө оруулагч улс болоод байна.


### **Хятадаас Монголд оруулж буй шууд хөрөнгө оруулалтын цар хэмжээ**

Хятадаас Монголд оруулж буй шууд хөрөнгө оруулалт нь Монгол Улсын төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үеийг дагалдаад гадаадад нээлттэй байх үйл явц тасралтгүй дээшилж, ялангуяа 1998 оноос хойш, Хятадаас Монголд оруулах шууд хөрөнгө оруулалт шинэ үе шатанд орлоо. Хятадын эдийн засгийн хурдацтай хөгжил болон гадаадын хөрөнгө оруулалтын чадвар байнга нэмэгдэж, Хятадаас Монголд оруулах шууд хөрөнгө оруулалтын хэмжээ далайц тасралтгүй өсч байна.

\*Түмэнцэцэг - Өвөр Монголын Их Сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн Хөрш орон судлалын хүрээлэнгийн захирал, судлаач

**Зураг 1. Хятадаас Монголд оруулж буй шууд хөрөнгө оруулалтын хэмжээ ба шинээр бүртгүүлсэн үйлдвэр аж ахуйн тоо**

(Хөрөнгө оруулалтын хэмжээний нэгж: сая ам.доллар;  
бүртгүүлсэн компаний тоо хэмжээ нэгж: ширхэг)




*Эх сурвалж: Монголын үйлдвэр худалдааны танхимийн статистик тоо баримт*

2008 оны эцэс гэхэд, Хятадаас Монголд оруулсан шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 1 тэрбум 679 сая ам.долларт хүрч, хөрөнгө оруулалтын хэмжээ гадаадын нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 55,73% болж, бүртгүүлсэн аж ахуйн нэгжийн тоо 4628 байгаа нь нийт бүртгэлтэй гадаадын компаний 49,62%-ийг эзэлж байна. Хятад улсад зөвхөн 2008 онд шинээр бүртгүүлсэн компани нь 859, шууд хөрөнгө оруулалт нь 498 сая ам.доллар болж, тус онд Монголд бүртгүүлсэн гадаадын компанийн хөрөнгө оруулалт 55%, 70%-ийг тус тус эзэлж байна.<sup>1</sup> 2008 оны Хятад, Монголын хооронд ажил үйлчилгээний 98 гэрээнд гарын үсэг зурж, гэрээний нийт дүн 8 тэрбум 355 сая ам.долларт хүрч, 2 тэрбум 804 сая ам.долларын гүйцэтгэл хийжээ.<sup>2</sup> 2009 он хүртэл Хятад улс 11 жил дараалан Монголд хамгийн том хөрөнгө оруулагч, 10 жил дараалан хамгийн том худалдааны түншийн байр сууриа хадгалж байна.

Дээр дурьдсан Хятадаас Монголд оруулсан хөрөнгө оруулалтын тоо бол Монголын худалдаа үйлдвэрлэлийн танхимийн статистик мэдээнд үндэслэсэн бөгөөд Хятадаас Монголд оруулж буй хөрөнгө оруулалтын статистикийн байдлыг харахад зөрөөтэй байгаа юм.

**Зураг 2. Хятадаас Монголд оруулж буй хөрөнгө оруулалтын урсгал хэмжээ ба байршсан хөрөнгө оруулалт (Нэгж: сая ам.доллар)**



*Эх сурвалж: 2008 оны Хятадын худалдааны оны лавлах.*

1, 2-р хүснэгтийн тоог харьцуулбал, Хятадаас Монголд оруулж буй хөрөнгө оруулалтын тухайд, 2 орны жил тутмын статистикийн тоо зөрүүтэй байна. Монголын статистикийн тоо бүртгэлээр хөрөнгө оруулалтын хэмжээ нь Хятадынхаас хол илүү гарч байна. Бид ийм байдал гарч байгаагийн шалтгаан бол Хятадаас Монголд оруулж буй шууд хөрөнгө оруулагчдын дийлэнх нь хувь хүмүүс буюу дунд, жижиг аж ахуйн нэгж, хэмжээ далайц бага, хөрөнгө оруулалтын дундаж хэмжээ ч бага, улсад бүртгэлгүй байдгаас хятадад тоо бүртгэлд орох аргагүй буюу тоо бүртгэл бүрэн биш байгаад юм гэж үзэж байна. Хятадын тал хөрөнгө оруулалтын тоо бүртгэл гаргахдаа үндэстэн дамнасан корпораци компаниуд Монголд капитал ба бусад элемент оруулсныг голлон анхаардаг. Иймээс хоёр орны тоо бүртгэл зөрж байна. Гэвч ерөнхийд нь хэлбэл, Хятадаас Монголд оруулж буй хөрөнгө оруулалтын хэмжээ жилээс жилд нэмэгдэх хандлагатай байна.

Хятадаас Монголд оруулж буй шууд хөрөнгө оруулалтын хэмжээ хурдан өсч байгаа нь хэд хэдэн хүчин зүйлтэй холбоотой.

1. Хятадаас гадаадад оруулж буй шууд хөрөнгө оруулалтын хэмжээ хурдацтай өсч байна.

**Хүснэгт 1. Хятадаас Монголд оруулж буй шууд хөрөнгө оруулалтын Хятадаас гадаадад оруулж буй шууд хөрөнгө оруулалтад эзлэх хувийн жин**

| Он  | 2003  | 2004  | 2005  | 2006  | 2007   | 2008   |
|---|-------|-------|-------|-------|--------|--------|
| Хятадаас гадаадад оруулсан хөрөнгө оруулалтын нийт (байршуулсан) хэмжээ /100 сая ам.доллар/ | 332.2 | 447.8 | 572.1 | 750.3 | 1179.1 | 1839.7 |
| Монголд оруулж буй шууд хөрөнгө оруулалтын (байршуулсан) хэмжээ                             | 0.039 | 0.169 | 0.229 | 0.420 | 0.502  | 0.487  |
| Хятадаас гадаадад оруулсан хөрөнгө оруулалтын нийт урсгал хэмжээ /100 сая ам.доллар/        | 28.5  | 55.0  | 122.6 | 176.3 | 265.1  | 559.1  |
| Монголд оруулж буй шууд хөрөнгө оруулалтын байршуулсан хэмжээ                               | 0.14  | 0.73  | 0.42  | 0.47  | 0.74   | 0.43   |

*Эх сурвалж: 2008 оны Хятадын худалдааны лавлахын тооцож гаргасанаар*

Хүснэгт 1-ээс Хятадын Монголд оруулж буй шууд хөрөнгө оруулалтын урсгал хэмжээг Хятадаас гадаадад оруулж буй нийт хөрөнгө оруулалтад эзлэх хувийн жинтэй харьцуулбал 2003 онд 0,14% байсанаа 2004 онд 0,73% болж түргэн өсч, 2004 оноос хойш хувийн жин тогтворгүй байсан хэдий ч сүүлийн 3 жил 0,5% орчим байсаар байна. Энд тайлбарлах нэг зүйл гэвэл хэдийгээр 1, 2-р зургаас харахад, сүүлийн хэдэн жилд Хятадаас Монголд оруулсан шууд хөрөнгө оруулалтын хэмжээ тасралтгүй өргөжиж, хурдан өсч байгаа боловч энэ нь зөвхөн Монгол Улсад гарч байгаа үзэгдэл биш, Хятадын эдийн засгийн хөгжлийг дагалдаад, гадаадад оруулж буй хөрөнгө оруулалтын цар хүрээ, хэмжээ ч мөн хурдан өсөж байгаагаас Монгол дахь шууд хөрөнгө оруулалт ч дагалдан өсөж байгаа юм.

2. Монголын уул уурхайн хайгуул, олборлолтод оруулах хөрөнгө оруулалт нэмэгдэж байна.

Хятадаас Монголд оруулах хөрөнгө оруулалтын хурдац нэмэгдэж буйн бас нэг шалтгаан бол Хятад, Монгол хоёр орны эдийн засгийн бүтэц адилгүй улмаас 2 талын эдийн засгийн хамтын ажиллагаанд маш хүчтэй харилцан нөхөх чанартайд оршино. Тухайлбал, Монгол Улсын зэс, нүүрс, төмөр, газрын тос зэрэг ашигт малтмалын нөөц баялаг нь хятадын өндөр хурдацтай эдийн засгийн хөгжилд дутагдаж буй түүхий эдийг нөхөхөд хэрэгтэй юм. Дээр нь газар зүйн ашигтай байрлалтай болохоор Хятад улс улам бүр том үйлдвэр аж ахуйн газар нээж ажиллуулах хөрөнгө оруулалтыг Монголын зах зээлд, ялангуяа уул уурхайн хайгуул, олборлолтонд оруулж байна. Уул уурхайн хайгуул олборлолтын ажлын онцлог бол урд нь оруулсан хөрөнгө оруулалтын өртөг их, иймээс тус салбар руу орж байгаа үйлдвэр аж ахуйн газар улам бүр олон болж, Хятадаас Монголд оруулж буй хөрөнгө оруулалтын хэмжээ маш хурдан нэмэгдэж байна.

Хятадын Худалдааны Яамнаас гаргасан Хятадын гадаад хөрөнгө оруулалтын хэмжээг харуулсан хүснэгтээс үзвэл, 2003 онд Монголд оруулсан урсгал хөрөнгө оруулалтын хэмжээ бусад олон оронд оруулсан хэмжээтэй харьцуулбал 28-р байранд, 2006 он гэхэд 11-р, 2008 онд 12-р байранд байв. 2007 онд Хятадаас гадаадад оруулж буй хөрөнгө оруулалтын урсгал хэмжээ 100 сая ам.доллар давсан 24 улс болон бүс нутгийн дотор Монгол Улс 15-р байранд оржээ.<sup>3</sup> Энэ нь сүүлийн жилүүдэд Хятад улс Монголын зах зээлийг анхаарч, хөрөнгө оруулалтаа тасралтгүй нэмэгдүүлж буйг бүрэн нотолж байна.

### **Монгол дахь Хятадын шууд хөрөнгө оруулалтын бүтэц**

Хятадын Монгол дахь хөрөнгө оруулалт Монгол Улсын бүхий л аж ахуйн салбарыг хамарч байгаа ч салбар бүрт эзлэх хувийн жин нь адилгүй байгаа юм.

### **Хүснэгт 2. Хятадаас Монголд оруулж буй шууд хөрөнгө оруулалтыг салбар бүрээр авч үзвэл /нэгж байгууллага: 100 сая ам.доллар/**

| №* | Хөрөнгө оруулсан ажил мэргэжлийн салбар          | Хувийн жин | Нийт хэмжээ | 1990-2004 | 2005   | 2006   | 2007   | 2008   |
|----|--|------------|-------------|-----------|--------|--------|--------|--------|
| 1  | Уул уурхайн хайгуул, олборлолт                   | 67.43      | 1.132.29    | 185.81    | 165.87 | 103.67 | 247.72 | 429.22 |
| 2  | Худалдаа, хоол ундны үйлчилгээ                   | 20.84      | 349.99      | 120.66    | 29.10  | 52.45  | 84.41  | 63.37  |
| 3  | Барилга, барилгын материал                       | 2.15       | 36.03       | 28.53     | 0.59   | 1.50   | 4.18   | 1.23   |
| 4  | Хөнгөн аж үйлдвэр                                | 1.39       | 23.32       | 22.74     | 0.30   | 0.07   |        | 0.21   |
| 5  | Мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр   | 1.36       | 22.79       | 17.77     | 0.83   | 3.65   | 0.54   |        |
| 6  | Хүнсний бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр        | 0.41       | 6.81        | 5.28      | 0.10   | 1.42   |        |        |
| 7  | Тээвэр   | 0.38       | 6.37        | 6.10      | 0.26   |        |        | 0.01   |
| 8  | Газар тариалан, мал аж ахуй                      | 0.29       | 4.88        | 3.83      | 0.84   |        | 0.21   |        |
| 9  | Эрчим хүч  | 0.22       | 3.77        | 3.69      | 0.08   |        |        |        |
| 10 | Мэдээлэл, холбооны үйлчилгээ                     | 0.19       | 3.12        | 1.54      | 0.39   |        | 1.19   |        |
| 11 | Гэрийн тавилга, модон эдлэлийн үйлдвэрлэл        | 0.17       | 2.81        | 2.64      | 0.02   |        |        | 0.14   |
| 12 | Аялал жуулчлал                                   | 0.12       | 1.96        | 0.72      | 0.51   |        | 0.21   | 0.47   |
| 13 | Эмнэлэг, эрүүлийг хамгаалах гоо сайхны үйлчилгээ | 0.11       | 1.89        | 1.89      |        | 0.01   |        |        |
| 14 | Цахилгаан барааны үйлдвэрлэл                     | 0.07       | 1.16        | 1.14      | 0.02   | 0.05   |        |        |
| 15 | Нийтийн үйлчилгээ                                | 0.05       | 0.80        | 0.78      | 0.02   |        |        |        |
| 16 | Гэр ахуйн барааны үйлдвэрлэл                     | 0.05       | 0.78        | 0.77      |        |        | 0.01   |        |
| 17 | Соёл, боловсрол, шинжлэх ухаан, техник           | 0.02       | 0.35        | 0.34      |        | 0.006  | 0.004  |        |
| 18 | Банк, санхүүгийн үйлчилгээ                       | 0.02       | 0.25        | 0.09      |        | 0.15   | 0.01   |        |
| 19 | Үнэт эдлэл, бэлэг дурсгалын бүтээгдэхүүн         | 0.01       | 0.15        | 0.15      |        |        |        |        |
| 20 | Бусад  | 4.74       | 79.60       | 37.32     | 28.98  | 9.02   | 1.13   | 3.16   |
|    | Нийт дүн   | 100        | 1.679.14    | 441.79    | 227.92 | 172.01 | 339.62 | 497.80 |

*Эх сурвалж: Монгол Улсын Худалдаа аж үйлдвэрийн танхимын статистик мэдээлэл*

Хүснэгт 2-оос Хятадаас Монголд оруулж буй шууд хөрөнгө оруулалтын гол таван салбар нь: Уул уурхайн хайгуул, олборлолт, худалдаа ба нийтийн хоолны үйлчилгээ, барилга, барилгын материал, хөнгөн үйлдвэр, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэр юм. 2008 оны эцэс гэхэд уул уурхайн хайгуул, олборлолтын салбарын хөрөнгө оруулалт Хятадаас Монголд оруулж буй нийт хөрөнгө оруулалтын бараг 70%-ийг эзэлж байна.

Худалдаа, нийтийн хоолны үйлчилгээний 20% орчим, бусад 3 салбар дахь хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 5% хүрэхгүй байна. Үлдсэн бусад салбарт эзлэх хөрөнгө оруулалтын хувийн жин дунджаар 5%-иас доош байна. Сүүлийн жилүүдэд Хятадаас Монголын уул уурхайн хайгуул, олборлолтод оруулж буй хөрөнгө оруулалт дардан замаар өсөх байдалтай болж, худалдаа, нийтийн хоол, барилгын салбар дахь хөрөнгө оруулалт 2008 онд буурч, харин уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалт бараг 200 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Ажил мэргэжлийн салбарын хөрөнгө оруулалтаас харахад, зөвхөн уул уурхайд оруулж буй хөрөнгө оруулалт 100 сая ам.доллараас давжээ.

### Хүснэгт 3. Монголд бүртгүүлсэн Хятадын аж ахуйн нэгжийн тоо салбар тус бүрээр

| №  | Хөрөнгө оруулсан ажил мэргэжлийн салбар          | Хувийн жин | Нийт хэмжээ | 1990-2004 | 2005 | 2006 | 2007 | 2008 |
|----|--|------------|-------------|-----------|------|------|------|------|
| 1  | Худалдаа, хоол ундны үйлчилгээ                   | 64.74      | 2996        | 380       | 290  | 637  | 839  | 850  |
| 2  | Барилга, барилгын материал                       | 5.06       | 234         | 193       | 11   | 11   | 17   | 2    |
| 3  | Мал аж ахуйн бүтээгдэхүүн, боловсруулах үйлдвэр  | 2.38       | 110         | 103       | 4    | 3    |      |      |
| 4  | Уул уурхайн хайгуул, олборлолт                   | 2.55       | 118         | 81        | 14   | 10   | 10   | 3    |
| 5  | Хөнгөн аж үйлдвэр                                | 1.90       | 88          | 78        | 5    | 5    |      |      |
| 6  | Хүнсний бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр        | 1.71       | 79          | 75        | 3    | 1    |      |      |
| 7  | Аялал жуулчлал                                   | 1.60       | 74          | 41        | 18   | 4    | 9    | 2    |
| 8  | Гэрийн тавилга, молон эдтэлийн үйлдвэр           | 1.10       | 51          | 47        | 2    | 2    |      |      |
| 9  | Тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл                | 0.99       | 46          | 40        | 3    | 2    | 1    |      |
| 10 | Тээвэр   | 0.58       | 27          | 20        | 4    | 2    |      | 1    |
| 11 | Мэдээлэл, холбооны үйлчилгээ                     | 0.43       | 20          | 16        | 1    | 3    |      |      |
| 12 | Эрчим хүч  | 0.35       | 16          | 15        | 1    |      |      |      |
| 13 | Нийтийн үйлчилгээ                                | 0.28       | 13          | 12        | 1    |      |      |      |
| 14 | Гэр ахуйн барааны үйлдвэрлэл                     | 0.28       | 13          | 13        |      |      |      |      |
| 15 | Эмнэлэг, эрүүдийг хамгаалах гоо сайхны үйлчилгээ | 0.26       | 12          | 12        |      |      |      |      |
| 16 | Шахилгаан барааны үйлдвэрлэл                     | 0.26       | 12          | 8         | 1    | 3    |      |      |
| 17 | Соёл, боловсрол, шинжлэх ухаан, техник           | 0.17       | 8           | 8         |      |      |      |      |
| 18 | Банк, санхүүгийн үйлчилгээ                       | 0.06       | 3           | 2         |      | 1    |      |      |
| 19 | Үнэт зэвсэг, бэлэг дурсгалын бүтээгдэхүүн        | 0.04       | 2           | 2         |      |      |      |      |
| 20 | Бусад  | 15.25      | 706         | 388       | 174  | 143  |      | 1    |
|    | Нийт дүн   | 100        | 4628        | 1534      | 532  | 827  | 876  | 859  |

*Эх сурвалж: Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимийн статистикийн материал*

3-р хүснэгтээс, Монголд бүртгэгдсэн Хятадын үйлдвэр аж ахуйн газрын бараг 70% нь худалдаа, хоолны үйлчилгээ эрхэлж, хөрөнгө оруулалтын хэмжээ нь уул уурхайн компаниудынхтай харьцуулбал ердөө 2,55% -ийг эзэлж, 2008 онд албан ёсоор бүртгэгдсэн компаний

тоо ердөө 3 байгааг бид харж болно. Түүнчлэн худалдаа, хоол ундны үйлчилгээ эрхэлдэг бүртгэлтэй аж ахуйн газар 850 байна. Энэ тоо нь Хятадаас Монголд шууд хөрөнгө оруулалтын нэг онцлог бол уул уурхайн хайгуул, олборлолтын томоохон аж ахуйн нэгжийг гол болгож, тоо хэмжээ нь бага хэдий ч хөрөнгө оруулалтын хэмжээ их, бусад салбарын хөрөнгө оруулалт нь дунд, жижиг аж ахуйг гол болгож, хөрөнгө оруулалт нь харьцангуй бага, цар хүрээ ч бага, гэхдээ бүртгүүлсэн аж ахуйн тоо их байна гэдгийг харуулж байна. Монголын Засгийн газар 2005 онд сонгон шалгаруулсан гадаадын шилдэг 20 аж ахуйн нэгжийн тоонд Хятадын 6 компани орсон 5 нь уул уурхайн салбарынх бөгөөд бүгд Хятадын доторх хүчтэй үндэстэн дамнасан корпорациуд байв. Тухайлбал, Дачин петролиум, Дуншэн петролиум, Хятадын өнгөт төмөрлөгийн компани гэх мэт. Түүнчлэн бусад улс, тухайлан Америк, Япон, БНСУ зэрэг Монголд томоохон хөрөнгө оруулагчид зөвхөн уул уурхайн салбараар зогсохгүй, холбоо мэдээлэл, эмнэлэг, интернет сүлжээ, соёл боловсрол, санхүү, хоол унд, зугаа цэнгэл /караоке/ зэрэг олон салбарыг хамарч, тухайн газартаа эдийн засгийн үр ашигтай, ард олны сайшаал хүлээж байна.

Хятад улс уул уурхайн салбараас гадна бусад салбарт ч ялангуяа ард түмний амьдралтай нягт холбоотой салбар, тухайлбал холбоо, эмнэлэг, интернет, хоол унд, зугаа цэнгэл, соёл боловсрол зэрэг дутагдаж буй нөлөөлөх салбарт хүчтэй хөрөнгө оруулалт хийж байна. Эдгээр салбарт хэдийгээр багагүй хөрөнгө оруулж байгаа ч жижиг дунд үйлдвэрийг гол болгодог ба эдгээр үйлдвэр аж ахуйн газрын техник технологи нэмэлт өртөг доогуур, тоног төхөөрөмж хоцрогдсон, цар хүрээ бага, хөрөнгө мөнгө дутагдалтай, өрсөлдөх чадвар муу, тухайн газрын ард иргэдэд хүлээн зөвшөөрөгдөх нь сайнгүй юм.

Монгол Улсын одоогийн байдлыг харвал, эдийн засгийн хөгжлийн түвшин Хятадаас хоцрогдсон, маш олон ажил үйлчилгээний салбарын технологийн түвшин олон улсын тэргүүний технологитой харьцуулбал хол ялгаатай байгаа учраас Монголын зах зээлийг ашиглах нөөц бололцоо их, үйлдвэрлэлийн технологийг сайжруулах орон зай ч их, Хятадын үйлдвэр, аж ахуйн газрын хувьд хөрөнгө оруулалт зөвхөн уул уурхайн салбарт төдийгүй, холбоо мэдээлэл, барилгын материал, аялал жуулчлал, мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, цахилгаан бараа зэрэг ажил үйлчилгээний салбарт ч мөн хөрөнгө оруулах хөгжлийн орон зай маш их байна.

### **Хятадын шууд хөрөнгө оруулалтын үйлдвэрлэлийн үр ашгийг задлан шинжлэх нь**

Хятадаас Монголд оруулж буй хөрөнгө оруулалт нэмэгдэж буй нь хоёр орны эдийн засаг, худалдааны харилцааны хөгжилд чухал ач

холбогдолтой, хоёр оронд ихээхэн ашигтай гэдэг нь эргэлзээгүй. Энэ өгүүлэлд хөрөнгө оруулагч орны үүднээс Монгол Улсын үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашгийг задлан шинжлэхэд.

### 1. Ажил олголт ба цалингийн түвшинд нөлөөлөх нь

Монгол Улсын тухайд яривал, олон улсын шууд хөрөнгө оруулалт тухайн улсын ажил олголтын боломжийг өсгөж магад. Үүгээр зогсохгүй олон улсын хөрөнгө оруулалт уригч орны ажил олголтод үр ашигтай байх болно.

“1994 оны Дэлхийн хөрөнгө оруулалтын илтгэл”-ийн үнэлгээгээр: шууд ажил олголт бүр 1-2 холбогдох ажил олголт татдаг учраас ажил олголтын нийт хэмжээ шууд ажил олголтын тооноос их байдаг.<sup>4</sup> Монгол Улсад сүүлийн хэдэн жил бүртгүүлсэн гадаадын хөрөнгө оруулалттай компаний тоог харахад, Монгол Улсад шинээр байгуулагдсан гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрийн тоо нэмэгдэж, хөдөлмөрийн төвлөрсөн шинжтэй үйлдвэрлэлийн объект нэлээд их хувийг эзэлж байна. Тухайлбал, уул уурхайн олборлолт, худалдаа, хоол ундны үйлчилгээ, барилга гэх мэт. Монголын засгийн газраас тогтоосон гадаадын харьяат ажилчдын тоог хязгаарласан бодлого, гадаадын хөрөнгө оруулалт тасралтгүй орж ирэхийн хэрээр тухайн газрын хүн амын ажилгүйдэл аяндаа багасч байгааг хэлэх хэрэгтэй.

Хамгийн том хөрөнгө оруулагч улс болохын хувьд Хятад улсын хөрөнгө оруулалтын хэмжээ ба хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн тоо гадаадын нийт хөрөнгө оруулалтын тал орчим хувийг эзэлж байна. Бүрэн бус мэдээгээр, 2005 оны эцэс гэхэд, Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд 80000 гаруй ажлын байр буй болгожээ. Түүний дотор хятадын хөрөнгө оруулалттай компаниуд 50 мянга гаруй ажлын байрыг бий болгож, тэдгээрт ажиллагсдын 6,3% монгол ажилчид байна.<sup>5</sup> Дээр дурьдсан “Дэлхийн хөрөнгө оруулалтын илтгэл”-ийн үнэлгээгээр, хэрвээ шууд ажил олголт бүр 1-2 холбогдох ажил олголтыг дагуулна гэж бодвол Хятадын хөрөнгө оруулалттай компаниуд Монголд ажил олголт бий болгох нөлөөлөл нь үүнээс ангид бус бөгөөд зохих хэмжээний ажил олголтыг бий болгож байна.

Монгол дахь Хятадын хөрөнгө оруулалттай аж үйлдвэрийн газарт, хятад дарга, инженер техникч, ажилчид 30 мянга гаруй байна. Монголын холбогдох байгууллагаас тогтоосоноор, Монгол дахь хятад ажилчин НГ гэсэн визтэй.<sup>6</sup> Сар бүр Монголын Хөдөлмөрийн Яаманд 216 мянган төгрөг /1060 юаньтай тэнцэнэ/ ажлын байрны зардал гэж төлнө. Иймээс Монгол дахь Хятадын хөрөнгө оруулалттай компаниуд одоо уул уурхайн хайгуул, олборлолт, худалдаа үйлчилгээ, барилга, барилгын материал, хөнгөн үйлдвэр, мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах зэрэг хөдөлмөр төвлөрсөн ба ашигт малтмал төвлөрсөн шинжтэй үйлдвэрлэлд гол хүчээ төвлөрүүлж байна.



Иймээс их хэмжээний ажиллах хүч оруулах хэрэгтэй байна. Багцаалсан тооцоогоор, Хятадын хөрөнгө оруулалттай компаниуд жил бүр Монголын Засгийн газарт барагцаалбал 30 тэрбум төгрөгийн ажлын байрны зардал төлж байна. /150 сая юаньтай тэнцүү/

Үүнээс гадна, Гадаадын шууд хөрөнгө оруулалт Монгол Улсын цалингийн дундаж түвшинг дээшлүүлээ.

**Хүснэгт 4. 2005-2008 онд Монгол Улсын  
сарын дундаж цалингийн түвшин**  
/Нэгж байгууллага: 10000 төгрөг/

| Он   | 2005  | 2006  | 2007  | 2008  |
|--|-------|-------|-------|-------|
| <i>Дундаж цалин</i>  |       |       |       |       |
| Үйлдвэр аж ахуйн төрөл   | 10,12 | 12,77 | 17,30 | 27,42 |
| 100% Монгол Улсын үйлдвэр  | 10.52 | 13.73 | 17.88 | 29.39 |
| Улсын үйлдвэр ба гадаадтай хамтарсан хөрөнгө оруулалттай үйлдвэр | 13.43 | 16.36 | 20.00 | 29.67 |
| 100%-ийн хувийн үйлдвэр  | 8.76  | 10.30 | 14.84 | 22.52 |
| Хувийн ба гадаадтай хамтарсан хөрөнгө оруулалттай үйлдвэр        | 12.82 | 16.76 | 25.37 | 36.28 |
| 100%-ийн гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэр, аж ахуйн газар    | 11.04 | 11.76 | 15.10 | 23.14 |

*Эх сурвалж: 2008 оны Монгол Улсын статистикийн эмхтгэл*

4-р хүснэгтээс харахад Монголд байгаа гадаадын хамтарсан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн ажилчдын сарын дундаж цалин улсын дундаж цалингаас өндөр байна. Ялангуяа Монголын бие даасан хувийн аж ахуйн нэгж буюу хамтарсан хөрөнгө оруулалттай үйлдвэрийн ажилчдын дундаж цалингийн хэмжээ нэлээд их байна. Дээрх статистикийн тоо баримтаас харахад гадаадын бие даасан хөрөнгө оруулалттай аж үйлдвэрийн монгол ажилчдын дундаж цалин бусад хамтарсан аж үйлдвэрийнхээс бага байна. Зохиогчийн үзэж байгаагаар, гадаадын бие даасан аж ахуйн нэгжийн ихэнх чухал албан тушаал бол техникийн ажилчид нь хөрөнгө оруулагчаас Монголд шууд томилогдсон ба монгол ажилчдын тоо 1-рт нэлээд бага, 2-рт зөвхөн хялбар ажил үүрэг гүйцэтгэж байгаа улмаас цалингийн хэмжээ харьцангуй бага байна гэж үзэж байна. Монгол, Хятад ажилчдын цалингийн түвшин Хятад улсын дотоод дахь мөн адил албан тушаалын цалингийн хэмжээг бодвол өндөр байна. Одоогийн байдлаар Монголд байгаа Хятадын жирийн ажилчдын сарын дундаж цалингийн түвшин 4000-5000 юань, /монгол төгрөгөөр шилжүүлбэл 800000-1000000 төгрөг/ байна. Хятад улсын дотоод дахь ижил албан тушаалтны цалингаас барагцаалбал 1000-2000 юань илүү байна. Иймээс Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй харьцангуй адил цалингийн түвшин тухайн орон нутгийн цалингийн түвшинг өөрчлөхөд

хүрчээ. Ялангуяа хамтарсан аж ахуй нэгжид энэ нь ил тод мэдрэгдэж байна.

Мэргэжлийн салбарын хийсэн дүгнэлтээр бол Монгол Улсын хөдөлмөрийн хүчний орлогын хэмжээ нь хамгийн их орлогын хэмжээнээс хамгийн их мөнгө олборлох салбар бол банк санхүүгийн салбар байсан. 2008 оны сарын дундаж цалингийн хэмжээ 471400 төгрөгт хүрч, удаах салбар нь уул, уурхайн хайгуул олборлолтын салбарын сарын дундаж цалин нь 328600 төгрөг хүрч тухайн жилийн сарын дундаж цалингийн хэмжээнээс хол давсан байна.<sup>7</sup> Монгол Улсын банк санхүү болон уул уурхайн хайгуулалт ашиглалтын салбар бол гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулж байгаа салбар бөгөөд Монгол Улсын томоохон банк, уул уурхайн үйлдвэр нь гадаадын дангаар хөрөнгө оруулагчид буюу хамтарсан хөрөнгө оруулалттай салбар юм. Монгол Улсын уул уурхайн хайгуул, олборлолтын салбарт гадаадын хөрөнгө оруулагчдын нийт дүнгийн 56%-ийг Хятад улс эзэлж байна. /2-р хүснэгт харах/ аж ахуй нэгжийн тооны хувьд 60% эзэлж байна /3-р хүснэгтээс үзнэ үү/.

Иймээс банк санхүүгийн салбар болон уул уурхайн салбар дахь цалингийн түвшин нь бусад салбарынхаас давуу байгаагын нэг шалтгаан нь гадаадын аж ахуйн нэгж буюу хамтарсан аж ахуйн нэгжийн цалингийн түвшин өндөр байгаатай холбоотой бөгөөд түүний дотор Хятадын хөрөнгө оруулалттай нэгж нь Монгол Улсын цалингийн түвшинг дээшлүүлэхэд түлхэц үзүүлж байгаа юм.


## 2. Экспорт, импорт болон олон улсын орлого зарлагын түвшинд үзүүлж байгаа нөлөө

Гадаадаас орж ирж байгаа шууд хөрөнгө оруулалт нь богино хугацаанд Монгол Улсын тухайн жилийн валютын дутагдалыг нөхөж байгаа бөгөөд экспортын хэлбэрээр гадаадаас орж ирж байгаа шууд хөрөнгө оруулалт нь Монгол Улсын экспортыг нэмэгдүүлж болох бөгөөд энэ нь тус улсын олон улсын орлого зарлагад идэвхитэй нөлөөлж болох учраас Монгол Улс нь гадаадын шууд хөрөнгө оруулалтаас богино хугацааны мэдэгдэхүйц ашиг оруулж байна.

Цаашдаа урт удаан хугацаанд гадаадын шууд хөрөнгө оруулалт нь зөвхөн хөрөнгийн бүртгэл төдий биш хөрөнгө мөнгөний цогц үйлдвэрлэлийн хүчин чадлын хил дамжуулан шилжүүлэхэд нөлөө үзүүлэх бөгөөд хөрөнгө оруулагч талын холбогдох түүхий эд, дундын бүтээгдэхүүн, капиталын барааны экспортонд сайн нөлөө үзүүлнэ. Иймээс Монгол Улсын олон улсын орлого зарлага нь богино хугацаанд үр ашиг нь хязгаарлагдмал юм. Хятад улс нь Монгол Улсын хамгийн том худалдааны түнш бөгөөд Монгол Улсад экспортын чанартай шууд хөрөнгө оруулалтыг гол болгож байгаа учраас Хятадаас Монголд оруулж байгаа шууд хөрөнгө оруулалтын өндөр хурдацтай хөгжил нь хоёр улсын олон улсын орлого, зарлагын түвшинд нөлөө үзүүлэх нь лавтай.


Доорхи хэдэн зурагнаас Монгол, Хятадын хөрөнгө оруулалтын худалдаа нь Монгол Улсын олон улсын орлого зарлагын тэнцвэрт байдлыг харж болно.

**Зураг 3. Хятад, Монголын худалдааны хэмжээ ба Хятадаас Монголд оруулж байгаа шууд хөрөнгө оруулалтын хэмжээтэй харьцуулсан байдал /нэгж байгууллага: сая ам. доллар/**



Тоо баримтын эх сурвалж нь: 2008 оны статистикийн гаргасан баримтаас

**Зураг 4.**



Тоо баримтын эх сурвалж нь: 2008 оны статистикийн гаргасан баримтаас

Зураг 4-ийн тоо баримтнаас харахад сүүлийн жилүүдэд Монгол Улсын гадаад худалдаа нь тасралтгүй өсөж байгаа бөгөөд гадаад худалдааны импортын хэмжээ нь экспортын хэмжээнээс өндөр байгаа тул

худалдааны харьцаа нь ашиггүй байдалд байна. 2006 онд худалдааны хэмжээ нь ашигтай гарсан боловч ашгийн хэмжээ нь тун бага байсан юм.

3-р зурагт үзүүлсэнээр Монгол, Хятадын худалдаа 1994 оноос ашигтай байдалд байж 2 улсын худалдааны зөрөө нь жил тутамд өсөж, экспортын өсөлтийн хэмжээнээс импортын өсөлтийн хэмжээ нь маш их өндөр байлаа. Монголоос Хятад руу гаргаж байгаа экспортын хэмжээ 1994 онд Монголын экспортын хэмжээний дөнгөж 20,5% эзэлж байсан бол 2008 онд 64,5% хүрч импортын хэмжээ 1994 онд Монгол Улсын нийт импортын хэмжээний 9,2% эзэлж байсан бол 2008 онд 27,7% хүртэл өссөн байна. Экспортын хэмжээ ба импортын эзлэх хэмжээ асар их байлаа. Хятад улстай барьж байсан энэхүү ашигтай харьцаа нь Монгол Улсын олон улсын орлого зарлагыг тэнцвэржүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

### Хүснэгт 5. Монгол Улс экспортлохоос өмнөх 10 нэрийн бүтээгдэхүүнийг жагсаавал Хятадын эзлэх хувийн жин

| №  | Бараа бүтээгдэхүүний нэр                    | Экспортын хэмжээ /100 сая ам.доллар/ | Хувийн жин | Хятадад экспортлож буй хэмжээ /100 сая ам.доллар/ | Хувийн жин |
|----|---|--------------------------------------|------------|---|------------|
| 1  | Зэсийн хүдэр болон зэсийн баяжмал           | 8.1140                               | 42.9       | 8.1140  | 99         |
| 2  | Боловсруулсан болон хагас боловсруулсан алт | 2.3487                               | 12.4       | 0.7658  | 32.6       |
| 3  | Ямааны самнасан ноолдур                     | 1.1427                               | 6.0        | 0.4876  | 42.6       |
| 4  | Молибден болон молибдений баяжмал           | 0.4779                               | 2.5        | 0.1779  | 37.2       |
| 5  | Жоншны уурхай хүдэр                         | 0.3504                               | 1.8        | 0.0237  | 6.7        |
| 6  | Боловсруулсан хонь, ямааны арьс             | 0.2499                               | 1.3        | 0.2265  | 90.6       |
| 7  | Ноолууран цамц, бэлэн бүтээгдэхүүн          | 0.1762                               | 0.9        | 0.0034  | 1.9        |
| 8  | Хонины ноос                                 | 0.0842                               | 0.4        | 0.0765  | 90.8       |
| 9  | Алдны дэв                                   | 0.0073                               | 0.03       | 0.0073  | 100        |
| 10 | Алдны сүүл                                  | 0.0062                               | 0.03       | 0.0062  | 100        |

*Эх сурвалж: SiRimo, “Хятад Монголын эдийн засаг, худалдаа харилцааны хөгжлийг эрэгцүүлэх, дун шинжилгээ, урьдчилан таамаглах, санал”<sup>8</sup> номноос авав.*

Хүснэгт 5-ийг харахад Монголоос Хятад руу экспортонд гаргаж байсан гол нэрийн бүтээгдэхүүн нь зэсийн хүдэр болон зэсийн баяжмал, молибден болон молибдений баяжмал зэрэг уул уурхай, мал аж ахуйн бүтээгдэхүүн юм. Хятадаас Монголд оруулж байгаа шууд хөрөнгө оруулалтын салбарын төрлөөс /зураг 2/ харахад ойрын жилүүдэд Хятадаас Монголын уул уурхайн салбарт оруулж байгаа хөрөнгө оруулалтын хэмжээ түргэн хурдацтай нэмэгдэж байгаа бөгөөд Хятадаас Монголд оруулж байгаа шууд хөрөнгө оруулалт нь талаас дээш хувийг эзэлж байна. Ийм учир зураг 3 илэрхийлсэнээр бол Хятадаас Монголд оруулж байгаа шууд хөрөнгө оруулалтын шугам ба Монголоос Хятад руу экспортолж байгаа хөгжлийн хандлага нь ижил байна. Энэ нь мөн Хятадын экспортын чанартай шууд хөрөнгө оруулалт нь Монгол Улсын худалдааны экспортонд идэвхитэй нөлөө үзүүлж байна. Хятадын улам олон аж ахуй нэгжүүд Монголын уул уурхайн салбарт орж зэс, алт,

нүүрс зэрэг баялгыг олзворлоход Хятадын улам олон аж ахуй нэгжүүд оролцож, мөн Хятадын эдийн засгийн хөгжил нь түүхий эдийн хэрэгцээг улам нэмэгдүүлэхийг шаардаж байгаа учраас Хятадаас Монгол руу оруулж байгаа шууд хөрөнгө оруулалт нь Хятад Монголын худалдааны хэмжээг улам өрөгжүүлэхэд мэдэгдэхүйц нэмэгдүүлэх нь дамжиггүй юм.

Монгол Улсын импортын талаас авч үзвэл: урт удаан хугацааны хөгжлийг дагаж уул уурхайн салбар болон бусад салбарт томоохон хэмжээний объект дараалан ашиглалтанд орж байгаа нь улам их хүнд оврын тоног төхөөрөмж болон холбогдох материалууд Монголын зах зээлд орж Монголын импортын хэмжээг нэмэгдүүлэх буюу зарим түүхий эдийн бүтээгдэхүүнийг боловсруулж, орон нутгийн холбогдох үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд нөлөө үзүүлэх болно.

### 3. Үйлдвэрлэлийн технолгийн түвшингийн талаархи үр ашиг

Одоогийн байдлаар Монгол Улсын аж үйлдвэрийн хөгжил нь анхан шатны хэмжээнд байгаа ба аж үйлдвэрийн цогц системийг байгуулж чадаагүй байна. Үйлдвэрлэлийн бүтцийн хэмжээ нь доогуур байгаа бөгөөд гүнзгийрүүлэн боловсруулах аж үйлдвэрийн салбар нь маш сул дорой, үйлдвэрийн техникийн түвшин олон улсын техникийн түвшингээс маш их хоцрогдсон байна. Хэдийгээр Монгол Улс нь дэлхийн хоёр дахь том ноолуурын үйлдвэрийн орон боловч тоног төхөөрөмжийн хоцрогдол, боловсруулах технологийн хэмжээ доогуур байгаа учраас зөвхөн түүхий эдээ экспортонд гаргахад түшиглэж байна. Уул уурхайн хайгуул олборлолтын салбар ч мөн л ийм байдалтай байна. Урт удаан хугацааны туршид Монгол Улс нь хямд үнэтэй анхан шатны боловсруулалттай түүхий эд болон өртөг багатай бүтээгдэхүүнийг экспортолж ирлээ. Сүүлийн 2 жилд Монгол Улсын Засгийн газар гүнзгийрүүлсэн боловсруулалтын салбарыг хөгжүүлэх зорилт тавьж гадаадын хөрөнгө оруулалттай гүнзгийрүүлсэн технологийг оруулж ирэхийг урамшуулж байгаа бөгөөд энэ нь уул уурхайн хайгуул олборлолтын салбар, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах салбарт тусгалаа олж байна.

Хятад Улс нь 30 жилийн өөрчлөн байгуулалт, нээлттэй бодлого явуулж, шинжлэх ухаан, техникийн түвшин хурдацтай хөгжиж, одоогийн байдлаар боловсронгуй техник тоног төхөөрөмж хангалттай, хөрөнгө мөнгөтэй болсон бөгөөд Монгол Улсын уул уурхайн олборлох салбар, боловсруулах үйлдвэрт хэрэгцээтэй хөрөнгө мөнгө болон техник нийлүүлэх хүчин чадалтай болсон юм. Монголын зах зээлд гадаадын олон корпорациуд орж ирэхийн хэрээр дотоод дахь тэргүүний техник технологийг Монголд оруулж ирж, манай үйлдвэрлэлийн техникийн түвшинг дээшлүүлэхэд нөлөө үзүүлэх нь гарцаагүй юм.

Тэргүүний техник технологийн өсөлтийн дагуу Монгол Улсын холбогдох салбарын ажилчдын техникийн түвшин зохих хэмжээгээр дээшилж Хятадын хөрөнгө оруулалттай аж үйлдвэр Монгол Улсын хөлсний ажилчдын шинэ мэдлэг техникийн шинэ мэдэгдэхүүн өгөх нь гарцаагүй бөгөөд ажлын орон тоо бий болгох чанарын түвшинг дээшүүлнэ.

Үүнээс гадна Хятад улсаас Монгол Улсад шууд оруулсан хөрөнгө нь Монголын олон үйлдвэрлэлийн хөгжилд нэмэр үзүүлсэн бөгөөд хамгийн

мэдэгдэхүйц нь зоогийн газрууд байна. Зоогийн газар эрхэлж буй хүний хэлснээр Улаанбаатарт байгаа зоог хоолны газар нь одоогийн байдлаар 200 гаруй байна. Тэр тусмаа энэ жилүүдэд Монголд суурьшиж байгаа хятад иргэдийн тоо эрс нэмэгдсэн нь Монголын худалдаа, жуулчлалыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж байна.

### **ДҮГНЭЛТ**

Дээр дурьдсан Хятадаас Монголд оруулж байгаа шууд хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, үр ашгийг заллан шинжилж үзэхэд, Хятадаас Монгол Улсад оруулж буй хөрөнгө оруулалтын цар хүрээ цаашид ч өсөж, хөрөнгө оруулалтын бүтэц ч улам зүй зохиостой болох хандлагатай болж байгаа ч хөрөнгө оруулалтын хэмжээ уул уурхайн салбарт төвлөрч, бусад салбарын хөрөнгө оруулалт нэлээд бага байгаа нь харагдаж байна.

Ихэнх тоо баримтаас үзэхэд Хятад улсаас Монголд оруулж байгаа шууд хөрөнгө оруулалт нь тухайн орон нутгийн ажил олголтын хэмжээ, чанарыг нэмэгдүүлээд зогсохгүй улмаар орон нутгийн цалингийн хэмжээ өсөхөд түлхэц үзүүлж байна. Үүнээс гадна Хятадын хөрөнгө оруулалтын төсөл нэмэгдэхийн хэрээр Монгол Улсын орлого зарлагын тэнцвэр болон үйлдвэрлэлийн технологийн түвшин сайжирахад идэвхитэй үр нөлөө үзүүлж байна.

### **ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ**

1. Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимын 2009 онд нийтэлсэн статистикийн тоо баримт
2. Хятадын Худалдааны Яам “2008 оны Хятадын худалдааны оны лавлах” Бээжин, 2009, 178-р тал
3. Хятадын Худалдааны Яам. “2008 оны Хятадын худалдааны лавлах”. Бээжин, 2009 он, 185-р тал
4. Чи Зяньхун “Олон улсын хөрөнгө оруулалтын сургалтын программ” Бээжин. Чинхуа Их Сургуулийн хэвлэлийн хороо 2005, 22-р тал
5. Рунь Хунгуан, Зивэй “Монгол Улсад зорчих нь” /дээд/ Хөх хот. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо 2006. 337-р тал
6. НГ виз буюу ажиллах виз хүчинтэй хугацааны дотор Монголын хилийн дотор ажил хөдөлмөр эрхэлж болно.
7. Монгол Улсын статистикийн төв. “2008 оны Монгол Улсын статистикийн тоо баримт”. Улаанбаатар 2009 он. 128-р тал
8. SiRimo, “Хятад Монголын эдийн засаг, худалдаа харилцааны хөгжлийг эрэгцүүлэх, дүн шинжилгээ, урьдчилан таамаглах, санал” нь “Хятад, Монголын эдийн засгийн харилцааны хөгжил ба чиг хандлагын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл”, Хөх хот, Өвөр Монголын Их сургуулийн дэргэдэх олон улс судлалын хүрээлэн, 2008 он, 26-р тал.

*Хятад хэлнээс орчуулсан Л.Бэгзжав, Д.Батжаргал*